

**Монгол Улс**  
**НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Өмнөговь аймгийн иргэний нийгмийн**  
**байгууллагатай хийсэн уулзалт**  
**2017 оны 9-р сарын 14**

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл [ibaatarkhuu@worldbank.org](mailto:ibaatarkhuu@worldbank.org) и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп нь (ДБГ) Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор 2017 оны 9 дугаар сарын 14-нд Өмнөговь аймгийн иргэний нийгмийн 20 байгууллагатай уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

1. Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
2. Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
3. Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p style="text-align: center;"><b>Дүн шинжилгээний баримт бичигт тусгах санал (боломж, сорилт, тулгамдсан асуудал ба ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга замууд)</b></p>	<p><b>Боломж</b></p> <ul style="list-style-type: none"><li>• Говийн бүсийн нэг давуу тал нь сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асар их боломж юм. Жишээ нь Монгол улс салхины эрчим хүчний нөөцөөрөө хоёрдугаарт ордог.</li><li>• Улсын хэмжээнд буюу говийн бүсэд аялал жуулчлал хамгийн том боломж мөн. Үлэг гүрвэлийн үлдэгдлийн үзмэртэй газар, музей зэрэг аялал жуулчлалын брэндүүдийг хөгжүүлэх боломжтой.</li><li>• Хөдөө аж ахуйн салбар хөгжих, ажлын байр бий болгох асар их боломжтой.</li><li>• Уул уурхайн салбар өнгөрсөн хугацаанд улс орны өсөлтөд чухал хүчин зүйл болсон.</li><li>• Хөгжлийг дэмжсэн өөр нэг хүчин зүйл бол олон улсын байгууллагуудын дэмжлэг байв. Боловсрол, эрүүл мэндийн салбарт олон төсөл амжилттай хэрэгжсэн.</li><li>• Хүлэмжид жимс жимсгэнэ, хүнсний ногоо тарьж ургуулах үйл ажиллагааг дэмжих хэрэгтэй. Говийн бүсэд хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарьж ургуулах боломж их байдаг ч энэ чиглэлээр бусад төслүүдэд хамруулдаггүй. Тус салбар нь ажлын байр бий болгоно.</li></ul> <p><b>Сорилтууд</b></p> <p><b>Засаглал:</b></p> <ul style="list-style-type: none"><li>• Ихэнх оролцогчид төр засгийн газрын тогтворгүй байдал, богино хугацааны бодлогыг гол тулгамдсан асуудал гэж тэмдэглэсэн. Улс төрийн ашиг сонирхлын улмаас орлогын тэгш хуваарилалт байхгүй. Авилгал нэмэгдсэн, ялангуяа уул уурхайн салбарт авилгал их байгаа нь улс орны эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөг бууруулж байна. Үүнийг шийдвэрлэхийн тулд засаглалын өргөн хүрээтэй асуудлыг шийдэх нь зүйтэй.</li><li>• Зарим оролцогчид уул уурхайн салбар төрийн тогтворгүй байдлыг бий болгосон гэж тэмдэглэсэн. Норвеги улсын туршлагаас судалж ашигт малтмалын нөөцийн удирдлагыг сайжруулах хэрэгтэй.</li></ul>

- Түүнчлэн засаглалын асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хүний хөгжлийг нэн тэргүүнд чухалчлан үзэх шаардлагатай. Олон хүмүүсийг хөгжүүлж, чадавхжуулснаар засаглалын асуудал аяндаа шийдвэрлэгдэнэ. Боловсролтой хүмүүс байгаль орчныг хамгаална.
- Төрөөс олон хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ч эмзэг бүлгийнхэнд хүрч байгаа хөтөлбөр цөөхөн байна. Жишээ нь, Өмнөговь аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд төр засгийн газар, төрөл бүрийн төсөл хөтөлбөрүүдээс дэмжлэг, санхүүжилт авч байгаагүй эсвэл маш бага хэмжээний дэмжлэг авсан байдаг. Төрийн бодлого туслалцаа дэмжлэг шаардлагатай байгаа хүмүүстээ хүрч чаддаггүй. Түүнчлэн хандивлагч байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд нь авилгал, засаглалын асуудлын улмаас бодит үр өгөөж хүртэгчиддээ хүрдэггүй.
- Төр хариуцлагын тогтолцоогүй байгаа нь хөгжилд саад учруулж байна.
- Сонгуулийн компани ажлын үеэр санаачилж, хэрэгжүүлэхээр амласан халамжийн хөтөлбөрүүд нь улс орны хөгжлийг удаашруулж байна. Энэ нь эдийн засагт дарамт учруулж, хүмүүсийг халамжаас хэт хамааралтай болгодог.
- Төрийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавихад ИНБ-ууд илүү оролцох шаардлагатай байна.

#### **Хүний хөгжил:**

- Хүний хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгөх нь зүйтэй. Өнгөрсөн хугацаанд боловсролын салбарт маш их хөрөнгө оруулалт хийсэн боловч тоног төхөөрөмж худалдан авахад илүү анхаарч, чадавхийг бэхжүүлэх чухал асуудлыг орхигдуулсан. Иргэдийн насан туршийн боловсролыг дэмжих хэрэгтэй.
- Байгаль орчин, нийгмийн асуудлуудад хандах байдлаас харахад хүмүүсийн сэтгэлгээ, хүн чанар доройтож байна. Хүмүүсийн хандлага, сэтгэлгээг өөрчлөх хэрэгтэй. Иргэдийн хандлага, сэтгэлгээг өөрчлөхөд чиглэсэн хөтөлбөр жишээ нь 1960 оны “Соёлын довтолгоо” шиг хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Хүний хөгжлийг бага насны хүүхдийн боловсролоос эхлэх.
- Боловсролын салбарын гол багана болсон багш нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх шаардлагатай. Боловсролын салбарын хөгжлийн асуудалд багшийн хөгжил орхигдсон байна.
- Хүмүүсийн сэтгэлгээг өөрчлөхөд анхаарах хэрэгтэй - ажлын үнэлэмж бага учраас хүмүүс урт хугацааны тогтвортой ажил хөдөлмөр эрхлэх бус богино хугацааны түр ажил хийхийг илүү үздэг болсон нь улс орны хөгжилд бэрхшээл болж байна.
- Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд - ахмад настангуудыг орхигдуулсан, ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулахад – ДББ-ээс дэмжлэг үзүүлэх.

#### **Сэргээгдэх эрчим хүч:**

- Салхи, нарны эрчим хүч зэрэг нөхөн сэргээгдэх байгалийн нөөцийг зохистой ашиглах бодлого, дэмжлэг байхгүй. Энэ салбарыг байгаа нөөцдөө тулгуурлан хөгжүүлэх асар их боломж бий. Энэ чиглэлээр илүү их санхүүжилт олгох хэрэгтэй.

#### **Байгаль орчин:**

- Улс орны тогтвортой хөгжлийг хангахад байгаль орчныг хамгаалах асуудлыг нэн тэргүүнд чухалчлан үзэх нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр иргэд мэдлэг, боловсрол багатай учраас иргэдийн байгаль орчныг хамгаалах мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх хэрэгтэй.
- Парисын гэрээнд Монгол улсын хүлээсэн үүргийг биелүүлэхийн тулд арилжааны томоохон банкууд нүүрстөрөгч өндөр ялгаруулдаг төслүүдийг

санхүүжүүлэхгүй байх нь зүйтэй. Жишээ нь нүүрс, цахилгаан станц, хорт утаа ихээр ялгаруулдаг машин зэрэгтэй холбоотой төслүүд.

- Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас бэлчээр улам доройтож байгаа нь тулгамдсан асуудал болж байна. Хур тунадас багатай, агаарын хэм өндөр байх болсон нь бэлчээрт нөлөөлж байна. Иймд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

**Эдийн засгийн хөгжил, ажлын байр, ажилгүйдэл:**

- Эдийн засгийн төрөлжсөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай.
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар бид их ярьдаг боловч энэ салбарыг хөгжүүлэх ерөнхий бодлого байдаггүй. Аялал жуулчлалын салбарын хөгжлийг салбарын ерөнхий зорилгоос эхлэн, шаардлагатай дэд бүтэц, хөрш орнуудтай холбох гэх мэтээр цогцоор нь авч үзэх ёстой.
- Ажилгүйдэл бол томоохон асуудал бөгөөд ядуурлын нэг шалтгаан мөн. Уул уурхайн салбар цөөн тооны ажлын байр бий болгосон, иймд ажлын байр ихээр бий болгох ЖДҮ-ийг хөгжүүлэхэд нэн тэргүүнд анхаарах шаардлагатай.
- Түүнчлэн хүмүүс олдсон ажлын боломжийг ашиглаж ажилд орохыг хүсдэггүй эсвэл хөдөлмөрийн зах зээл дээр байхгүй байгаа өндөр цалинтай ажил хайдаг. Хүмүүс ажлаа тогтмол сольдог, урт хугацаанд тогтвортой ажиллахыг хүсдэггүй, ихэнхдээ ажлаа хаях буюу гардаг, бичил уул уурхай эсвэл гадаад ажиллах гэх мэт албан бус салбарт түр хугацаанд ажиллахыг илүүд үздэг.
- Өмнөх үеийнхтэй харьцуулахад ажилчдын ур чадвар муудсан, иргэд хангалттай мэргэжлийн боловсрол эзэмшээгүй байдаг. Олон салбарт техникийн мэргэжилтнүүдийн эрэлт ихтэй байгаа боловч ТМБС төгсөгчид ажлын байрны шаардлагыг хангах түвшинд бэлтгэгдээгүй байна.
- Ажилгүйдлийн бүртгэлийн аргачлалыг дахин судалж үзэх шаардлагатай. Ажилгүй иргэдийн зарим нь бүртгэлтэй, зарим нь бүртгэлгүй байна. Бүртгэлд хамрагдсан хүмүүс сар бүр дахин бүртгүүлэх шаардлагатай. Сар бүр бүртгүүлэхгүй бол тухайн иргэнийг ажилгүй иргэдийн бүртгэлийн системээс хасдаг учраас ажилгүйдлийн түвшинг бодит байдлаар тусгаж чаддаггүй.
- ЖДҮ-ийн зах зээлийн хүртээмж, өртгийн сүлжээг хөгжүүлэх шаардлагатай. Иргэд зарим бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг боловч маркетинг, зах зээлд нэвтрэх боломж, хүртээмж нь хязгаарлагдмал учраас энэ салбар хөгжихгүй байна.
- ЖДҮ-ийг төрөлжүүлэх шаардлагатай. Одоогийн байдлаар төрөөс ЖДҮ-үүдэд зарим санхүүжилтийн дэмжлэг үзүүлж байгаач ЖДҮ-ийг хөгжүүлэх нэгдсэн бодлого, зах зээлийн судалгаа байхгүй байна. Тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэггүй олон жижиг аж ахуйн нэгжүүдэд санхүүжилтийг хуваарилдаг. Үүний оронд илүү тогтвортой, бодитой үр дүнд хүрэхийн тулд цөөн тооны аж ахуйн нэгжүүдэд ахиу хэмжээний санхүүжилт олгох хэрэгтэй.
- Хоршоо, өргөтгөлийг Монгол улсад хөгжүүлэх хэрэгтэй. Нэн тэргүүнд Бодлого боловсруулагчдын дунд энэ чиглэлээр ухуулга сурталчилгаа хийх, ойлголтыг дээшлүүлэх, тэдний дэмжлэгийг авах нь зүйтэй.

**Хөдөө аж ахуй:**

- Уул уурхайн салбар нь өнгөрсөн хугацаанд өсөлтийг хангасан хүчин зүйл байсан боловч ирээдүйн өсөлтийг хангах хүчин зүйл биш юм. Ашигт малтмалын нөөц дуусдаг, байгаль орчны хувьд тогтворгүй байдаг. Иймд Өмнөговь аймгийн орон нутгийн эдийн засаг, амьжиргааг дэмжих хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх шаардлагатай.
- Мал аж ахуйн салбар нь хөдөө орон нутгийн эдийн засгийн дийлэнх хувийг эзэлдэг учраас тус салбарыг цогцоор нь дэмжиж хөгжүүлэх хэрэгтэй.

	<p><b>Уул уурхай:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Тогтвортой бичил уурхайн бодлого аймгийн түвшинд байдаггүй. Энэ нь хүмүүсийн амьжиргаа, ажлын байранд нөлөөлдөг учраас илүү анхаарал хандуулах хэрэгтэй.</li> <li>• Уул уурхайн салбар нь малчдаас бэлчээрийг нь авдаг учраас малчдын амьжиргаанд нөлөөлдөг.</li> <li>• Аймаг, сумын түвшинд мэдэгдэж, зөвлөлдөхгүйгээр компаниудад уул уурхайн лиценз олгож байгаагаас малчид улам бүр бэлчээргүй болж байна. Газрын удирдлагыг сайжруулах хэрэгтэй.</li> </ul>
<p><b>ДБГ-ийн стратеги ба түншлэлийн баримт бичигт тусгах санал</b></p>	<p><b>Хандлага ба хэрэгжилт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• ДБГ-ийн төслүүдийг ихэвчлэн засгийн газраар дамжуулан хэрэгжүүлдэг. ДБГ нь удирдлага, үйл ажиллагааныхаа арга барилыг өөрчилж, ИНБ-ууд, хувийн хэвшил болон бусад оролцогч талуудтай шууд харилцан ажиллах хэрэгтэй. ДБГ нь аливаа төсөл хэрэгжүүлэхээсээ өмнө үр дүнгийн илүү тогтвортой хүрээг бий болгож, төслийн амжилтыг энэхүү үр дүнгийн хүрээнд дурдсан үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэх ёстой. Үнэлгээг төрийн албан хаагчдын санал дүгнэлт бус, төслийн үр өгөөжийг хүртэгчдийн санал дүгнэлтэд тулгуурлан хийх нь зүйтэй.</li> <li>• ДБГ нь нийт санхүүжилтийн аль хэсгийг ямар оролцогч талд олгох талаар илүү дэлгэрэнгүй нарийвчилсан шаардлагыг тогтоох хэрэгтэй. Тухайлбал ИНБ-ууд, төслийн үр өгөөжийг шууд хүртэгчид, төр засгийн газар, хувийн хэвшилд олгох санхүүжилтийн хувь хэмжээг тодорхойлох гэх мэт. Учир нь санхүүжилтийн дийлэнхийг төр ихэвчлэн ашигладаг, ард түмэн санхүүжилтийн үр өгөөжийг хүртдэггүй.</li> <li>• Төслийн үр дүнгийн мониторинг, үнэлгээг сайжруулахад ДБГ анхаарах шаардлагатай.</li> <li>• Тогтвортой амьжиргаа төслийн хэрэгжилтийг Өмнөговь аймаг болон бусад аймгийн ИНБ-ын сүлжээ гэх мэт хөндлөнгийн этгээд үнэлсэн учраас тус төсөл нь амжилттай хэрэгжсэн.</li> </ul>
	<p><b>Салбарууд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Ихэнх оролцогчид ДБГ хөдөө аж ахуй, хүний хөгжил, аж үйлдвэрийн хөгжил, засаглалын салбаруудад дэмжлэг үзүүлэхэд анхаарлаа хандуулах хэрэгтэйг онцолсон юм.</li> <li>• Сүү цуглуулах сүлжээ ба сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах нь томоохон боломж юм. Иймд ДБГ нь сүү цуглуулах сүлжээ, сүүний үйлдвэрийг хөгжүүлэх томоохон төсөл хэрэгжүүлж болно.</li> <li>• ДБГ нь ИНБ-уудын чадавхийг бэхжүүлэх, хүний хөгжлийг дэмжих ёстой. Монгол улс нь дотоодын нөөц бололцоогоороо тоног төхөөрөмж худалдан авах боломжтой учраас цаашид тоног төхөөрөмж нийлүүлэх шаардлагагүй.</li> <li>• Одоо мөрдөж буй хууль тогтоомж нь социализмын үеийн хуучин хууль тогтоомжид тулгуурласан байдаг учраас ДБГ нь Монгол улсын хөдөлмөр эрхлэлтийн хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Аймаг бүрт салбартай үйлдвэрчний эвлэлтэй энэ чиглэлээр хамтран ажиллах боломжтой.</li> <li>• Хот суурин газар руу чиглэсэн шилжих хөдөлгөөн болон үүнээс үүдэлтэй олон асуудлыг шийдвэрлэхийн тулд ДБГ нь хөдөөгийн хөгжилд анхаарч илүү дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.</li> <li>• Хөрөнгө оруулалтын гэрээнүүдэд хөндлөнгийн хяналт тавихад ДБГ-ээс дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Гадаадын хөрөнгө оруулагчидтай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээнүүд нь Монгол улсын хэрэгцээ шаардлага бус гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашигт илүү нийцсэн байдаг.</li> </ul>

<b>Бусад</b>	<ul style="list-style-type: none"> <li>Зарим оролцогчид ДБГ-ийн төслүүд амжилттай хэрэгжиж, Монгол улсын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулж байгааг сайшаан тэмдэглэсэн.</li> </ul>
--------------	--

Уулзалтын үеэр авсан судалгааны дүн:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Төрийн удирдлага/шинэтгэл	12	60%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	11	55%
— Авлигатай тэмцэх	7	35%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	7	35%
— Хүнсний аюулгүй байдал	7	35%
— Боловсрол	6	30%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	6	30%
— Хөдөөгийн хөгжил	6	30%
— Эрүүл мэнд	6	30%
— Эдийн засгийн өсөлт	6	30%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	5	25%
— Эрх тэгш боломжоор хангах	5	25%
— Нийгмийн хамгаалал	5	25%
— Ус, ариун цэврийн байгууламж	5	25%
— Санхүүгийн зах зээл	3	15%
— Гадаадын хөрөнгө оруулалт	3	15%
— Зам, тээвэр	3	15%
— Эрчим хүч	3	15%
— Байгалийн нөөцийн удирдлага	2	10%
— Худалдаа, экспорт	2	10%
— Хотын хөгжил	1	5%
— Гамшгийн эрсдэлийн удирдлага	0	0%
— Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	0	0%
— Бусад	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДББ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

Хүний хөгжлийг дэмжих	16	80%
Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	13	65%
Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	7	35%
Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	6	30%
Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	6	30%
Бүгд чухал	5	25%